Мөлхөө холтсон цэцэг (*Ranunculus repens L.*) ургамлын талаар Уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолуудаас тодруулах нь

Б.Халиун[1], А.Батжаргал[1], Р.Наранхүү[1], Б.Цэрэнцоо[2], Д.Цэрэндагва[3]

[1]АШУҮИС, МАУОУС
[2]АШУҮИС, МАУОУС, Уламжлалт Жор Судлалын Тэнхим
[3]АШУҮИС, МАУОУС, Дотор Өвчин Судлалын Тэнхим
Цахим хаяг: khaku.bud@gmail.com, Утас: 99547174, 99242596

Түлхүүр үг:

Ranunculus repens L
Уламжлалт жор
Хавдрын эсрэг нөлөө
Жэцасэрво

Товч утга:

Үндэслэл: Мөлхөө холтсон цэцэг нь анемонин, протоанемонин, ранункулин, изоранункулин, β-ситостерол, флавоноидын бүлгийн флавон глюкозид, тритерпен сапониний ангиллын бодисуудыг агуулдаг бөгөөд ходоод, улаан хоолой, бүдүүн гэдэсний хорт хавдрын эсрэг нөлөө үзүүлэх зэрэг олон үйлдэлтэй нь судлагдсан тул Уламжлалт анагаах ухаан болон Угсаатны анагаах ухаан дахь хэрэглээг тодруулах нь зүйтэй юм. **Зорилго:** Мөлхөө холтсон цэцэг ургамал агуулсан жор найрлагууд, тэдгээрийн үйлдлийг Уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолуудаас тодруулан судлах. **Арга, аргачлал:** Судалгааг эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга болон задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргуудаар хийлээ. **Үр дүн:** Мөлхөө холтсон цэцэг буюу “Жэцасэрво” (Төвөд нэр) нь “Эм таних ухаан” зохиолд хүйтэн бэтгийг анагаах, “Хөх бидэр” зохиолд хоолой хаагдах бадган, төмөр хагт бадган өвчнийг анагаах чадалтай гэж тэмдэглэгджээ. Мөн аюулхайн бадган, хоолой хаагдах бадган, төмөр хагт бадган, халуун, хүйтэн бэтэг өвчнүүдийн үед дангаар болон нийлмэл жор болгон хэрэглэх тухай “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”, “Маш гайхамшигт хуримын сан”, “Нандин эрдэнийн шимийн хураангуй”, “Увдисын үндэсний нэмсэн арга оршивой” зэрэг сурвалж зохиолуудад тэмдэглэсэн байдаг.[8-10] **Дүгнэлт:** Мөлхөө холтсон цэцэг буюу *Ranunculus repens L.* ургамлын Уламжлалт анагаах ухаанд баримталж ирсэн эмчилгээний арга, өвчний заалтын талаар сурвалж зохиолуудаас тодруулан харьцуулан судлахад төстэй байдлаар тэмдэглэгдсэн байна.

Үндэслэл: Мөлхөө холтсон цэцэг буюу *Ranunculus repens L.* нь Ranunculaceae -ийн овогт багтдаг. Ranunculaceae буюу Холтсон цэцэгтний овог нь дор хаяж 62 зүйлийн 2.200 ургамлаас бүрддэг. Үүнээс 720 орчим нь Хятад орон даяар тархдаг бөгөөд ихэнх нь баруун өмнөд уулархаг нутагт ургадаг гэж судлаач Hao D.C нарын бүтээлд тэмдэглэжээ.[1,2] Харин манай оронд 26 зүйл нь ургадаг байна[3]. Орчин үеийн анагаах ухаанд Мөлхөө холтсон цэцэг ургамлын үйлдэл, түүнд агуулагдах биологийн идэвхт нэгдэл зэргийг судалсан судалгаанууд цөөнгүй бий. Жишээлбэл: анемонин, протоанемонин, ранункулин, изоранункулин, β-ситостерол, флавоноидын бүлгийн флавон глюкозид, тритерпен сапониний ангиллын бодисуудыг Мөлхөө холтсон цэцэг болон түүний зүйлд хамаарах ургамлуудаас илрүүлж ялган судалсан байдаг.[5,6] Мөн зарим зүйлийн ургамал нь хавдрын эсрэг нөлөө үзүүлдэг болохыг судалгаагаар тогтоосон байдаг.[7]

Харин Уламжлалт анагаах ухаанд Мөлхөө холтсон цэцэг буюу “Жэцасэрво” (Төвөд нэр) нь гашуун, халуун амттай, бүлээн чадалтай. Илчийг үүсгэж, илжирснийг таслан, шар усыг хатаах чадалтай.[8] Голдуу хүйтэн бэтэг, шар ус хурсан, усан хаван, амьсгал амаргүй ханиах, бие шарлах, толгой

аюулхай өвдөх, ям, яр, нүд бүрхэх, ходоод элэгний бэтэг зэргийг арилгана гэж үздэг. Иймд бид Мөлхөө холтсон цэцэг ургамлын үйлдэл, үйлчилгээг “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”, “Маш гайхамшигт хуримын сан”, “Нандин эрдэнийн шимийн хураангуй” “Увдисын үндэсний нэмсэн арга оршивой”, “Тонвагажод буюу Үзэгсдийн баясгалан”,”Эм таних ухаан”, “Хөх бидэр” зэрэг Уламжлалт анагаах ухааны сурвалж зохиолуудаас судаллаа.

Зорилго, зорилт: Уламжлалт анагаах ухааны сурвалж болон тайлбар бүтээлүүдийн хүрээнд Мөлхөө холтсон цэцэг ургамал орсон жор, найрлагууд болон түүний үйлдлийг тодруулан судлах.

Арга аргачлал: “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс”, “Маш гайхамшигт хуримын сан”, “Нандин эрдэнийн шимийн хураангуй”, “Увдисын үндэсний нэмсэн арга оршивой”, “Тонвагажод буюу Үзэгсдийн баясгалан”, “Эм таних ухаан”, “Хөх бидэр” зэрэг зохиолуудын зохих хэсгийг хэрэглэгдэхүүн болгож эх бичиг, сурвалж судлалын харьцуулах арга болон задлан шинжилж, нэгтгэн дүгнэх аргуудаар судалгааг хийлээ.

Үр дүн: Монголын нэрт оточ, эрдэмтэн Чойжамцын 1922 онд туурвисан “Маш гайхамшигт хуримын сан” зохиолд Талва ава-гийн найрлаганд жэца, юмон, срүвгаагийн үнс ордог ба халуун хүйтэн бэтэгний зүйл бүгдэд сайн гэж тэмдэглэсэн байдаг.[9] Уламжлалт Анагаах Ухааны гол сурвалжуудад “Өвсөн гурван халуун” хэмээх ойлголтонд жэцасэрво (Мөлхөө холтсон цэцэг), юмонгарво (Сибирь чөдөр өвс), срүвга (Бунгийн яргуй)-г авч үздэг.[10] Энэхүү нийлмэл жор нь шарх хатиг анагаах, хүйтэн бэтгийг эвдэх, хавдар хариулах, илжирснийг таслан, илчийг үүсгэж, шар усыг татах, нян нядлах, тамиржуулах чадалтай гэж тэмдэглэсэн байдаг.[11] Ходоодны хүйтэн бэтэг, аюулхайн бадган, хоолой хаагдах бадган, төмөр хагт бадган өвчнүүдийн үед дээрх гурван эмт ургамлыг эрт дээр үеэс хэрэглэсээр ирсэн байна. Мөн “Анагаах Ухааны Дөрвөн Үндэс” зохиолд хоолой хаагдах бадган өвчнийг засахад 5 халуун, 4 сайн, өмхий давирхай, жиданга, молор давс, өрлөг цэцэг, холтсон цэцэг зэргийн талхыг түүхий балтай найруулж өгөх, эсвэл догшин номхотгосон жоншны үнсэн эмийг найруулж өглөө оройдоо буцалсан усаар уулгавал тустай гэж тэмдэглэсэн байдаг ба “Увдисын үндэсний нэмсэн арга оршивой” хэмээх зохиолд хоолой хаагдах бадган өвчний үед өвсөн гурван халуун жорыг хэрэглэх талаар дурдсан байдаг.[8]

Түүнчлэн Мөлхөө холтсон цэцэг ургамлын эрдэм, чадлын талаар дараах сурвалж зохиолуудад тэмдэглэгдсэн байдаг.

Хүснэгт 1. Уламжлалт сурвалж зохиолуудад тэмдэглэгдсэн Мөлхөө холтсон цэцэг ургамлын эрдэм, чадал

д/д	Сурвалж зохиолууд	Эрдэм, чадал
1	Анагаах ухааны дөрвөн үндэс	Илчийг үүсгэж, илжирснийг таслан, шар усыг хатаах[8]
2	Цахар гэвш Лувсанчүлтэмийн “Эм таних ухаан’’	Хүйтэн бэтэг, сахуугийн зүйлийг арилган, усан хаванг хатаах[12]
3	Дэсрид Санжаажамцын “Хөх бидэр”	Төмөр хагт бадган болон хоолой хагт бадган өвчнийг анагаах[13]
4	Чойжамцын “Маш гайхамшигт хуримын сан”	Илчийг үүсгэн хорхойг нядлах, шар усыг татаж бэтгийг эвдэх[9]
5	Жигмэдданзанжамц-ийн “Тонвагажод буюу Үзэгсдийн баясгалан”	Илчийг үүсгэж, шар усыг татах ба ялзрахыг зогсоох[14]
6	Монгол эмийн ухаантан Найман хошууны Жамбалдоржийн зохиосон “Монгол эмийг зөв таних толь”	Илжирснийг таслан, илчийг үүсгэж, шар усыг татна[15]

Нийт зургаан сурвалж зохиолд Мөлхөө холтсон цэцэг ургамлын эрдэм, чадлыг тэмдэглэсэн байна.

Хэлцэмж: “Алтан хадмал” зохиолд “Нөхөр үгүй ганц бадганд хурцыг найруул, догшин сарлагийн эврийн талх, өвсөн гурван халуун, шудаг, шингүнийг жүглэн дээр нэмж, араатны мах ясыг чанасан сүмсээр зуурах буюу эсвээс жамц, лалапүд, асаму /юмон/, библин, гаа нугуудыг зэргээр нэмж, бүхэн лүгээ хувь сацуу арүрын өвсөн эмийг найруулбал энэхүү гал адил найрлага нь илчийг үүсгэхийн дээд гэжээ”.[17] Мөн “Манагренчинжунай” зохиолын бадган өвчнийг засах бүлэгт: “Галт хүрээний найралт”-д төмөр ороонго, бэтэг өвчнийг засах бүлэгт: “Хүйтэн бэтгийн галт найралт”, “Бэтгийн очир найралт” зэрэг жоруудад өвсөн гурван халууныг оруулж хэрэглэх талаар заасан байдаг.[16] Энэ мэт Мөлхөө холтсон цэцэг ургамал агуулсан эмт жорын үйлдлийн талаар сурвалж зохиолуудад тэмдэглэсэн байна.

Түүнчлэн уламжлалт жор найрлага болон эмт ургамлыг сурвалж зохиолуудаас тодруулан судлах судалгааны ажил түгээмэл хийгддэг. Жишээ нь: Ee-rdungaowa, Ч.Батнайрамдал, С.Сээсрэгдорж нарын “Уламжлалт сурвалж зарим тайлбар бүтээлүүдээс халдварт халуун өвчнийг анагаах жоруудыг харьцуулан судалсан нь”, Жин Юн Ли, Б.Цэрэнтогтох, С.Цогтсайхан, С.Сээсрэгдорж нарын “Хар хэрэх өвчний эмийн эмчилгээний уламжлалт сурвалж бичгийн судалгаа” гэх зэрэг юм.[15] Харин Р.Наранхүү нарын “Ходоодны хавдрын эсэд өвсөн гурван халууны үзүүлэх нөлөө” сэдэвт бүтээлд Өвсөн гурван халуун болон сурвалж зохиолуудаас тодруулан судалж “Өвсөн гурван халууны жишиг итгэлцүүрийг тооцоход

бадганыг дарах жишиг итгэлцүүр=0,097. Гашуун, гошуун амттай, бадганыг дарах хөнгөн, ширүүн, хурц, халууны чадал өндөр байгааг дүгнэн гаргасан байдаг. [16]

Дүгнэлт: Мөлхөө холтсон цэцэг буюу *Ranunculus repens L*. ургамлын Уламжлалт анагаах ухаанд баримталж ирсэн эмчилгээний арга, өвчний заалтын талаар сурвалж зохиолуудаас тодруулан харьцуулан судлахад төстэй байдлаар тэмдэглэгдсэн байна.

Ном зүй:

1. *Hao D.C., Xiao P.G., Ma H., Peng Y., He C.N. Mining chemodiversity from biodiversity: pharmacophylogeny of medicinal plants of the Ranunculaceae. Chin. J. Nat. Med. 2015;13(7):507–520.*
2. *Xiao P.G. A preliminary study of the correlation between phylogeny, chemical constituents and pharmaceutical aspects in the taxa of Chinese Ranunculaceae. Acta Phytotax. Sin. 1980;18(2):142–153.*
3. *Urgamal M, Oyuntsetseg B, Department of Biology Conspectus of the Vascular Plants of Mongolia, DN and CD, 2014; 81-82.*
4. *Лигаа.У, Даваасүрэн.Б, Нинжил.Н. Монгол орны эмийн ургамлыг өрнө дорнын анагаах ухаанд хэрэглэхүй. УБ. 2005; 408*
5. *Khan WN, Lodhi MA, Ali I, et al, New natural urease inhibitors from Ranunculus repens. Journal of Enzyme Inhibition and Medicinal Chemistry, 2006; 21(1): 17-19.*
6. *Hao D-C, Biodiversity, Chemodiversity, and Pharmacotherapy of Ranunculus Medicinal Plants, Elsevier Inc, 2019.*
7. *Hao D.C., Xiao P.G., Ma H., Peng Y., He C.N. Mining chemodiversity from biodiversity: pharmacophylogeny of medicinal plants of the Ranunculaceae. Chin. J. Nat. Med. 2015;13(7):507–520.*
8. *Анагаах Ухааны Дөрвөн Үндэс УБ 1991; 152-154. Хөрвүүлсэн Х.Тумбаа.*
9. *Чойжамц. Маш гайхамшигт хуримын сан. Хэвлэлд бэлтгэсэн З.Мэндсайхан. УБ. 1991; 123*
10. *Лувсанчойнбал. Нандин эрдэнийн шимийн хураангуй. УБ 1993; 47. Хэвлэлд бэлтгэсэн Б.Пүрэвсүрэн, З.Мэндсайхан.*
11. *Жигмэдданзанжамц. Тонвагажод. Өвөр Монголын Ардын Эвлэлийн Хороо. 1996; 10-11.*
12. *Цахар гэвш Лувсанчүлтэм. Эм таних ухаан. ӨМАХХороо.1998; 82-90*
13. *Дэсрид Санжаажамц. Бидэронбо. Дунд дэвтэр. ӨМАХХороо 1984; 36*
14. *Жигмэдданзанжамц. Тонвагажод Өвөр Монголын Ардын Хэвлэлийн Хороо. 1996; 10-11*
15. *Отгонбаяр.Д нар. Монголын анагаахын шинжлэх ухааны Эрдмийн чуулган-62. УБ. 2020; 169-170*
16. *Нарахүү. Н. Ходоодны хавдрын (AGS) эсэд "Өвсөн гурван халуун"-ы үзүүлэх нөлөө. Анагаах Ухааны магистрын зэрэг горилсон нэг сэдэвт бүтээл. УБ. 2018; 61*
17. *Дармаамааранба Лувсанчойдог. Алтан хадмал. ӨМАХХороо. Шилийн гол аймгийн монгол эмийг судлах газар.1984; 1179*

Clarifying about the *Ranunculus repens L*. plant from The Traditional Medical Literatures

Khaliun B[1], Batjargal A[1], Narankhuu R[1], Tserentsoo B[2], Tserendagva D[3]

[1]MNUMS, International School of Mongolian Medicine
[2]MNUMS, International School of Mongolian Medicine, Department of Traditional Prescriptionology
[3]MNUMS, International School of Mongolian Medicine, Department of Internal Medicine
Email: khaku.bud@gmail.com, Tel: 99547174

Introduction: As it has been studied that *Ranunculus repens L*. contains anemonin, protoanemonin, ranunculin, isoranunculin, β-sitosterol, flavonoid group's flavon glucosid, triterpen saponins and has an effect against gastric, esophageal, and large intestine cancer, we aimed to study and clarify this plant's application in traditional medicine from the traditional medicine literature.

Objective: We aimed to clarify and study prescriptions that include this therapeutically significant *Ranunculus repens L* plant and its' function from the Traditional Medical literature.

Method: The study was made using the descriptive research method.

Result: In literature called "Em tanikh ukhaan" *Ranunculus repens L*, as known as "Jetsaservo", is written as capable of curing cold tumor and in literature "Huh bider", it has a potency to cure gulgag baekan disorders and chaagdek baekan disorders. Moreover, in literature such as "Four roots of medicine", "Mash gaihamshigt hurimiin san", "Nandin erdeniin shimiin huraangui", "Evdisin undesnii nemsen arga orshivoi", it is stated that it can be used by itself or with other herbs to make a compound to treat gulgag baekan disorders, chaagdek baekan disorders, hot and cold tumor.

Conclusion: From comparing and studying *Ranunculus repens L*.'s traditional medical treatment, disorder indication in many literature, it has been found that it is written in a resemblant way.

Keyword: Ranunculus repens L, Traditional drug, anticancer effect, Jetsaservo